

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ДҮРЭМ-175**НИСЭХИЙН МЭДЭЭЛЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГА, ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭЛТ**

А БҮЛЭГ . ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	3
175.1. Зорилго.....	3
175.3. Тодорхойлолт, товчлол	3
175.5. Гэрчилгээжүүлэлтийн шаардлага.....	4
175.7. Өргөдөл гаргах.....	4
175.9. Гэрчилгээ олгох	4
175.11. Гэрчилгээгээр олгогдох эрх.....	4
175.13. Гэрчилгээний хугацаа.....	4
175.15. Гэрчилгээний хугацаа сунгах.....	4
Б БҮЛЭГ . ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭЛТЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА.....	5
175.51. Боловсон хүчинд тавигдах шаардлага.....	5
175.53. Ажиллах орчинд тавигдах шаардлага.....	5
175.55. Нислэгийн өмнөх мэдээллийн үйлчилгээний хамрах хүрээ	6
175.57. Баримтжуулалт.....	6
175.59. Мэдээлэл цуглуулах.....	6
175.61. Нисэхийн мэдээллийг хэвлэх.....	7
175.63. Хэвлэгдсэн мэдээллийн алдааг залруулах.....	8
175.65. Бүртгэл.....	9
175.67. Дотоод чанарын хангалт.....	9
175.69. Байгууллагын үйл ажиллагааны заавар	10
В БҮЛЭГ. ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ ШААРДЛАГА	11
175.101. Ерөнхий шаардлага	11
175.103. Нисэхийн мэдээллийн эмхтгэлийн үйлчилгээ	11
175.105. NOTAM мэдээний үйлчилгээ	12
175.107. Нислэгийн өмнөх мэдээллийн үйлчилгээ.....	12
175.109. Гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагааны өөрчлөлт	13
175.111. Аюулгүй ажиллагааны шалгалт ба аудит.....	14
Г БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН НИСЭХИЙН МЭДЭЭЛЛИЙН ЭМХТГЭЛ	14
175.151. Монгол Улсын НМЭ-ийн агуулга	14
175.153. Монгол Улсын НМЭ-д тавигдах шаардлага	15
175.155. НМЭ-ийн өөрчлөлтөнд тавигдах шаардлага	16
175.157. НМЭ-ийн нэмэлтэнд тавигдах шаардлага.....	16
Д БҮЛЭГ. НИСЭХИЙН МЭДЭЭЛЛИЙН ЦУВРАЛ	17
175.201. НМЦ-ын агуулга.....	17
175.203. НМЦ-д тавигдах шаардлага.....	17

Е БҮЛЭГ. NOTAM МЭДЭЭ.....	18
175.251. NOTAM мэдээний агуулга	18
175.253. NOTAM мэдээнд тавигдах шаардлага.....	19
175.255. NOTAM мэдээг түгээх.....	20
ХАВСРАЛТ 1	21

Зам, тээвэр, барилга хот байгуулалтын сайдын
2010 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн
78 тоот тушаалын 2 дугаар хавсралт

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ДҮРЭМ-175

НИСЭХИЙН МЭДЭЭЛЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГА, ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭЛТ

А БҮЛЭГ . ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

175.1. Зорилго

(а) Энэ дүрмийн зорилго нь Нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагыг гэрчилгээжүүлэх, түүний үйл ажиллагаанд болон нисэхийн мэдээллийн нэгдсэн багцын элементүүдэд тавигдах шаардлагыг тогтооход оршино.

175.3. Тодорхойлолт, товчлол

Бүрэн бүтэн байдал (нисэхийн өгөгдөл) гэж нисэхийн өгөгдлүүдийн эх болон нэмэлт өөрчлөлт оруулсан хувилбарууд нь тоо, хэмжээний өөрчлөлтгүйг батлах түвшинг;

Зөвшөөрөгдөх хэмжээ гэж хэмжсэн, эсхүл тооцоолсон утгыг хэрэглэх ба илэрхийлэхэд зөвшөөрөгдөх нэгж, эсхүл тоог;

Мөшгөх боломж гэж авч үзэж байгаа зүйлийн өмнөх түүх, хэрэглээ буюу байршлыг хайн олох боломж (MNS ISO 9000:2001);

Нарийвчлалын хэмжээ гэж тооцолсон, эсхүл хэмжсэн утгыг бодит утгатай нийцүүлсэн хэмжээ;

Нислэгийн өмнөх мэдээллийн товхимол гэж нислэг эхлэхээс өмнө бэлтгэгдсэн нислэгийн үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой хүчинтэй NOTAM мэдээнүүд;

Нисэхийн мэдээллийн зохицуулалт ба хяналт (цаашид AIRAC гэх) гэж үйл ажиллагаанд гарч байгаа чухал өөрчлөлтүүдийг Олон улсын иргэний нисэхийн байгууллага (цаашид ICAO гэх)-аас тогтоосон хүчинтэй болох өдрүүдэд тохируулан урьдчилан зарлах зорилго бүхий тогтолцоог;

Нисэхийн мэдээллийн үйлчилгээний бүтээгдэхүүн гэж нисэхийн зургаар болон нисэхийн мэдээллийн нэгдсэн багцын элемент (NOTAM болон Нислэгийн өмнөх мэдээллийн товхимол үүнд хамаарахгүй)-ийн хэлбэрээр эсхүл тохирох электрон хэлбэрээр түгээх нисэхийн мэдээллийг;

NOTAM гэж нисэхийн тоног төхөөрөмж, үйлчилгээ, журмыг шинээр нэвтрүүлэх, өөрчлөх, эсхүл тэдгээрт үүссэн нөхцөл байдлын талаар болон нислэгт нөлөөлөх аюултай нөхцөлийн талаар нислэгийн үйл ажиллагаанд оролцож байгаа этгээдэд цаг тухайд нь урьдчилан мэдэгдэх зайлшгүй шаардлагатай, цахилгаан холбоогоор тараагдах мэдээг;

Олон улсын NOTAM-ын нэгж гэж тухайн улсаас томилогдсон олон улсын хэмжээнд NOTAM мэдээ солилцох үүрэгтэй нэгжийг;

Цасны NOTAM гэж хөдөлгөөний талбайд цас, мөс, шалбааг, тогтоол усны улмаас аюултай нөхцөл байдал бий болсон, эсхүл үүссэн нөхцөл байдлыг арилгасан талаар зохих маягтаар мэдээлдэг тусгай серийн NOTAM мэдээг.

175.5. Гэрчилгээжүүлэлтийн шаардлага

(а) Энэ дүрмийн дагуу Нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллага (цаашид НМҮБ гэх)-ын гэрчилгээ эзэмшигчээс өөр бусад байгууллага, этгээд Монгол Улсын нислэгийн мэдээллийн районд нисэхийн мэдээлийн үйлчилгээ (цаашид НМҮ гэх) эрхлэхийг хориглоно.

175.7. Өргөдөл гаргах

(а) НМҮБ-ын гэрчилгээ эзэмшихээр өргөдөл гаргагч (цаашид Өргөдөл гаргагч гэх) нь ИНЕГ-175/01 маягтыг бөглөн энэ дүрмийн 175.69-д заасан Үйл ажиллагааны зааврыг төлбөрийн баримтын хамт Иргэний нисэхийн ерөнхий газар (цаашид ИНЕГ гэх)-ын даргад ирүүлнэ.

175.9. Гэрчилгээ олгох

(а) ИНЕГ-ын дарга нь НМҮБ-ын гэрчилгээг дараах нөхцөлд олгоно:

1/ өргөдөл гаргагч энэ дүрмийн Б бүлгийн шаардлагыг хангасан байх;

2/ өргөдөл гаргагч болон түүний удирдах албан тушаалтан, эсхүл энэ дүрмийн 175.51-ын (а)-ийн 1/, 2/-т заасан ажилтнууд нь тухайн ажлын байранд тавих шаардлагад нийцэж тохирсон байх;

3/ гэрчилгээ олгосноор нисэхийн аюулгүй ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй;

175.11. Гэрчилгээгээр олгогдох эрх

(а) Гэрчилгээ эзэмшигч нь тухайн гэрчилгээнд тусгагдсан Нисэхийн мэдээллийн үйлчилгээг эрхлэх эрхтэй.

175.13. Гэрчилгээний хугацаа

(а) Гэрчилгээг 3 жил хүртэлх хугацаагаар олгоно.

(б) Гэрчилгээ нь түүний хүчинтэй хугацаа дууссан, эсхүл ИНЕГ-аас гэрчилгээний үйлчлэлийг түр түдгэлзүүлсэн буюу хүчингүй болгосноос бусад тохиолдолд хүчин төгөлдөр байна.

(в) Гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээний хүчинтэй хугацаа дууссан, эсхүл хүчингүй болсон тохиолдолд гэрчилгээг ИНЕГ-ын даргад ирүүлнэ.

(г) Гэрчилгээний үйлчлэлийг түр түдгэлзүүлсэн тохиолдолд тухайн гэрчилгээг сэргээх асуудлаар гэрчилгээ эзэмшигч нь ИНЕГ-ын даргад хандаж болно.

175.15. Гэрчилгээний хугацаа сунгах

(а) Гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээний хүчинтэй хугацааг сунгуулах өргөдлийг ИНЕГ-175/01 маягтын дагуу гаргаж, гэрчилгээний хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө ИНЕГ-ын даргад ирүүлнэ.

Б БҮЛЭГ . ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭЛТЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

175.51. Боловсон хүчинд тавигдах шаардлага

(а) Өргөдөл гаргагч нь дараах албан тушаалтан, ажилтантай байна:

- 1/ эрхэлж байгаа НМҮ, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа нь энэ дүрмийн шаардлагад нийцэж байгааг болон зохих шаардлагын дагуу санхүүжиж байгааг бататгах эрх бүхий удирдах албан тушаалтан;
- 2/ байгууллагын үйл ажиллагааг энэ дүрмийн шаардлагад нийцүүлж явуулах үүрэг бүхий өөрийн удирдах албан тушаалтны өмнө хариуцлага хүлээх ажилтнууд;
- 3/ эрхлэх НМҮ-нээс хамааран нисэхийн мэдээллийг цуглуулах, харьцуулан үзэх, нэгтгэх, шалгах, зохицуулах, боловсруулах, хадгалах, хэвлэх үйл ажиллагааг гүйцэтгэх эрх олгогдсон хангалттай тооны боловсон хүчинтэй байна.

(б) Өргөдөл гаргагч нь дараах журмыг тогтоож мөрдөнө:

- 1/ НМҮ-ний ажилтныг сонгон шалгаруулах, сургаж, дадлагажуулах журам;
- 2/ НМҮ-ний ажилтны мэргэжлийн ур чадварыг хадгалах, дээшлүүлэх журам;
- 3/ Энэ зүйлийн 175.51-ийн (а)-хэсгийн 3/-т заасан ажилтнуудад тухайн ажлыг гүйцэтгэх эрх олгох журам;

175.53. Ажиллах орчинд тавигдах шаардлага

(а) Өргөдөл гаргагчийн ажлын байр нь эрхлэх нисэхийн мэдээллийн үйлчилгээний төрөл болон энэхүү дүрмийн шаардлагад нийцсэн байна:

- 1/ нисэх багт нислэгийн өмнөх мэдээллийн үйлчилгээ (цаашид НӨМҮ гэх) үзүүлэхэд ойр, тусгайлан тоноглогдсон танхим;
- 2/ НМҮ-ний ажилтныг сургаж, дадлагажуулахад зориулан тусгайлан тоноглогдсон танхим;
- 3/ НМҮ-ний бүтээгдэхүүнийг хэвлэх, ангилж, ялгахад зориулан тоноглогдсон өрөө;
- 4/ ээлжийн ажилтнууд алжаал ядаргаагааг тайлахад зориулагдсан амралтын өрөө;
- 5/ ээлжийн ажилтнууд хувцсаа солиход зориулсан шүүгээ;
- 6/ НМҮ эрхлэхэд зайлшгүй шаардлагатай дараах тоног төхөөрөмж, хэрэгсэлтэй байна:
 - 6.1. гадаад орнуудын НМҮБ болон Монгол Улсын нислэгийн мэдээллийн районы нислэгийн мэдээллийн төв, бүсийн удирдлагын төвүүдтэй харилцах хоёр талын холбооны AFTN сүлжээ;
 - 6.2. нисэх баг, нислэгийн үйл ажиллагаанд оролцогч байгууллага, хүмүүсийг шаардлагатай мэдээллээр найдвартай, түргэн шуурхай хангах зориулалт бүхий AFTN сүлжээнд холбогдсон мэдээллийн автомат систем;
 - 6.3. цахилгаан эрчим хүчээр найдвартай хангах хэрэгсэл;
 - 6.4. өндөр хурдны интернет сүлжээнд холбогдсон шаардлага хангахуйц хурд, багтаамжтай компьютер, хэвлэх төхөөрөмж;
 - 6.5. газрын зураг, зураг зүйн бүтээгдэхүүн хэвлэх төхөөрөмж;
 - 6.6. саадын мэдээллийн сан бүрдүүлэх боломжтой тоон газрын зураг;
 - 6.7. олон улсын цагийг харж тооцох зориулалт бүхий ханын цаг;

6.8. мэдээлэл хүлээн авах, дамжуулах гадаад, дотоод гарцтай, соронзон бичлэг хийх телефон утсан холбоо;

6.9. мэдээлэл хүлээн авах, дамжуулах төхөөрөмж /факс/;

6.10. мэдээллийг олшруулан хувилах машин.

(б) Энэ зүйлийн (а) хэсгийн 6/-д заасан тоног төхөөрөмжүүдийн гэнэтийн саатал, татгалзал, ашиглалт ба хүчин чадлын түвшингийн бууралт, нислэгийн аюулгүй ажиллагаанд сөргөөр нөлөөлөх магадлалыг багасгахад зориулагдсан нөөц тоног төхөөрөмжтэй байна.

175.55. Нислэгийн өмнөх мэдээллийн үйлчилгээний хамрах хүрээ

(а) Өргөдөл гаргагч нь үйл ажиллагааны заавартаа тусгагдсан Нислэгийн өмнөх мэдээллийн үйлчилгээ (цаашид НӨМҮ гэх)-ний хамрах хүрээг тогтоосон газарзүйн бүс болон аэродромууд ба тэдгээрээс эхлэх агаарын замуудыг тус тус өргөдөлдөө тодорхой заана.

175.57. Баримтжуулалт

(а) Өргөдөл гаргагч нь:

- 1/ гэрчилгээгээр олгогдох эрхийн дагуу хэвлэвэл зохих нисэхийн мэдээллийн маягт болон загварыг баримтжуулна;
- 2/ нисэхийн мэдээллийн маягт болон загвар нь мэдээллийг ашиглах онцлог нөхцөлд нийцсэн байхыг бататгана;
- 3/ үйл ажиллагааны зааварт тусгагдсан НМҮ эрхлэхэд шаардлагатай лавлах материал, стандарт, зөвлөмж, журам болон бусад баримт бичгийн хуулбаруудыг бэлэн байлгана.

(б) Өргөдөл гаргагч нь энэ зүйлийн (а) хэсэгт заасан баримт бичгүүдийг хянах зорилгоор дараах зүйлсийг тусгасан журамтай байна:

- 1/ баримт бичгийг хэвлэхээс өмнө түүний хангалттай эсэхийг зохих ажилтан хянан баталгаажуулж байх;
- 2/ баримт бичигт дүн шинжилгээ хийж, шаардлагатай бол шинэчилж байх;
- 3/ баримт бичгийн өөрчлөлт, хянаж шинэчилсэн төлөв байдлыг ил тод тодорхой байлгах;
- 4/ хэрэгцээт баримт бичгийг хэрэглэх газарт зохих хувилбараар нь бэлэн байлгах;
- 5/ баримт бичиг нь гаргацтай, тод бөгөөд ялган таньж олоход хялбар байлгах;
- 6/ гадны гарал үүсэлтэй баримт бичгийг бүртгэн тодруулж тэдгээрийн түгээлтийг хяналттай байлгах;
- 7/ хуучирсан баримт бичгийг хэрэглэхээс сэргийлж, түүнийг аливаа нэгэн зорилгоор хадгалж байгаа бол тухайн баримт бичгийг сайтар бүртгэн тэмдэгжүүлэх.

175.59. Мэдээлэл цуглуулах

(а) Өргөдөл гаргагч нь НМҮ эрхлэх үйлчилгээнд шаардлагатай мэдээллийг цуглуулах, харьцуулан дүгнэх журмыг тогтоож, Үйл ажиллагааны заавартаа тусгана.

(б) Энэ зүйлийн (а)-д заасан журам нь дараах зүйлсийг тусгасан байна:

- 1/ цуглуулах түүхий мэдээлэлд тавигдах шаардлагыг тогтоосон байх;
- 2/ шаардлага хангасан мэдээллийг Монгол Улсын агаарын навигацийн тогтолцоонд үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудаас хүлээн авсан байх;
- 3/ Монгол Улсаас эхлэх олон улсын нислэгийн үйл ажиллагаанд ашиглагдах холбогдох мэдээллийг бусад улсын НМҮБ-аас хүлээн авсан байх;
- 4/ Нислэгийн өмнөх болон нислэгийн үед шаардлагатай мэдээллийг мэдээллийн

- бусад баталгаат эх үүсвэрээс авсан байх;
- 5/ энэ зүйлийн (б) хэсгийн 2/, 3/-т дурьдсан мэдээлэгч байгууллагууд нь мэдээллээр цаг тухайд нь хангаж байх талаар харилцан тохиролцсон байх;
 - 6/ энэ зүйлийн (б) хэсгийн 2/-т заасан мэдээлэгч байгууллагуудаас хүлээн авсан мэдээлэл нь тухайн байгууллагаас томилогдсон, мэдээллийн үнэн зөвд хариуцлага хүлээх албан тушаалтнаар баталгаажуулагдсан байх;
 - 7/ ирүүлсэн түүхий мэдээлэл нь NOTAM мэдээгээр зарлагдах бол хүчин төгөлдөр байх хугацааг 3 сараас дээшгүй байхаар тусгах.

175.61. Нисэхийн мэдээллийг хэвлэх

(а) Өргөдөл гаргагч нь НМҮБ-ын эрхлэх үйлчилгээнд шаардлагатай нисэхийн мэдээлэл/өгөгдөл, нисэхийн мэдээллийн нэгдсэн багцын элементүүдийг үүсгэх, нэгтгэх, шалгах, зохицуулах, боловсруулах, хадгалах, хэвлэх, тараах журмыг тогтоож, Үйл ажиллагааны заавартаа тусгана.

(б) Энэ зүйлийн (а) хэсэгт заасан журам нь дараах зүйлсийг тусгасан байна:

- 1/ энэ дүрмийн 175.59 зүйлд заасны дагуу хүлээн авсан мэдээллийг хэвлэн гаргахаас өмнө боломжит мэдээлэл ашиглан түүний үнэн зөвийг баталгаажуулан шалгах;
- 2/ энэ дүрмийн 175.59 зүйлд заасны дагуу хүлээн авсан мэдээллийг боловсруулах, хэвлэх, тараах:
 - 2.1. тохирох загварт оруулах ба энэ нь мэдээллийг ашиглах нөхцөлийг тооцсон байх;
 - 2.2. боломжтой бол энэ дүрмийн Г, Д, Е бүлэгт заасан шаардлагад нийцүүлэх;
- 3/ энэ зүйлийн (б) хэсгийн 4/-т зааснаас бусад тогтмол болон урт хугацаатай, түр шинж чанартай хэвлэл нь өргөдөл гаргагчид олгогдсон эрхийн дагуу хэвлэгдсэнийг илэрхийлсэн тэмдэглэгээтэй байх;
- 4/ хэрэв энэ дүрмийн 175.59 зүйлийн (б) хэсгийн 2/-т заасны дагуу бусад орны НМҮБ-с хүлээн авсан нисэхийн мэдээллийг тараах тохиолдолд тухайн орны эрх бүхий байгууллагаас хүлээн авсан гэдгийг тодорхойлох тэмдэглэгээтэй байх;
- 5/ энэ дүрмийн 175.59 зүйлийн (б) хэсгийн 6/-д заасан шаардлагын дагуу баталгаажуулагдаагүй мэдээллийг түгээх бол уг мэдээллийг баталгаажуулан шалгагдаагүйг тодорхойлсон тэмдэглэгээтэй байх;
- 6/ хэвлэгдсэн тогтмол мэдээлэлд өөрчлөлт оруулах тохиолдолд тухайн өөрчлөлтийг хэвлэхээс өмнө холбогдох бусад мэдээлэгчидтэй хэлэлцсэн байх;
- 7/ түр шинж чанартай мэдээллийн дуусах хугацааг нь тодорхой бусаар хэвлэсэн бол түүнийг мэдээлэгчээс тухайн мэдээллийг цуцлах эсхүл сунгах арга хэмжээ авч болохуйц хугацааны өмнө дахин тодруулах;
- 8/ нисэхийн мэдээллийг хэрэглэх байдлаас нь шалтгаалан монгол, англи хэлээр хэвлэх;
- 9/ нисэхийн мэдээллийн нэгдсэн багцад англи хэлээр хэвлэх монгол нэрийг латин үсгээр галиглаж бичих;
- 10/ хэмжих нэгжүүд нь Монгол Улсын Хэмжлийн нэгжийн MNS ISO–1000:2002 стандартад нийцсэн байх;
- 11/ хэвтээ хавтгай дахь болон босоо хавтгай дахь тооллын тогтолцоо нь Монгол Улсын Засгийн газрын геодезийн солбилцол, өндөр, нэгдсэн тогтолцооны тогтоолтой нийцсэн байх;
- 12/ хугацааны тооллын тогтолцоонд ашиглагдах байдлаас шалтгаалан Монгол Улсын эсхүл Гринвичийн голчийн цагийг ашиглах;
- 13/ ИНД-1-т орсон товчлол нь хэрэглэхэд тохиромжтой, мэдээллийн түгээлтийг хялбарчилж байвал хэвлэгдэх нисэхийн мэдээлэлд ашиглах;

- 14/ агаарын навигацийн аюулгүй ажиллагаа, тогтвортой байдал болон үр ашигтай байдлыг хангах үүднээс аливаа нисэхийн мэдээлэл/өгөгдлийг бусад орны НМҮБ-аас шаардсан тохиолдолд нэн даруй дамжуулах боломжтой байх;
- 15/ агаарын навигацийн аюулгүй ажиллагаа, тогтвортой байдал болон үр ашигтай байдлыг хангах үүднээс аливаа нисэхийн мэдээлэл/өгөгдлийг дор дурьдсан хэрэглэгчдийн үйл ажиллагаанд шаардлагатай үед тохирох хэлбэрээр бэлэн байлгах. Үүнд:
- 15.1. нисэх баг, нислэгийн үйл ажиллагаа хариуцсан ажилтнууд, нислэгийн төлөвлөлт болон нислэгийн сургалт, дадлага явуулдаг байгууллагууд;
- 15.2. нислэгийн мэдээллийн үйлчилгээ үзүүлдэг нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний нэгж болон нислэгийн өмнөх мэдээллийн үйлчилгээний нэгж.

(в) Өргөдөл гаргагч нь Нисэхийн мэдээллийн эмхэтгэл (цаашид НМЭ гэх)-ийн талаар дараах зүйлсийг Үйл ажиллагааны заавартаа тусгаж бататгана:

- 1/ НМЭ-ийн өөрчлөлт, нэмэлтээр хэвлэгдэх нислэгийн зураг болон үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой мэдээг AIRAC-ын тогтолцооны дагуу хэвлэх;
- 2/ AIRAC-ын тогтолцооны дагуу хэвлэгдэх мэдээлэл нь AIRAC гэсэн тэмдэглэгээтэй байх;
- 3/ AIRAC-ын тогтолцооны дагуу хэвлэгдсэн мэдээллийг түгээхдээ уг мэдээллийн хүчинтэй болох хугацаанаас 28 хоногийн өмнө хэрэглэгчдэд хүрсэн байхаар тооцох, цаасан хэлбэрээр бэлтгэсэн мэдээллийг нь хүчин төгөлдөр болох өдрөөс 42 хоногийн өмнө түгээх;
- 4/ AIRAC-ын тогтолцооны дагуу хэвлэгдсэн мэдээллийг хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 28 хоногийн хугацаанд түр шинж чанартай өөрчлөлт гарахаас бусад тохиолдолд өөрчлөхгүй байх;
- 5/ томоохон өөрчлөлт төлөвлөгдсөн үед урьдчилан мэдээлэх нь тустай тохиолдолд бололцоотой бол нисэхийн мэдээллийг хүчин төгөлдөр болохоос 56 хоногийн өмнө түгээх.
- 6/ NOTAM мэдээг НМЭ-ийн нэмэлтээр оруулах тохиолдолд тухайн NOTAM мэдээний дугаарыг оруулах;
- 7/ НМЭ-ийн өөрчлөлт болон нэмэлт нь AIRAC-ын тогтолцооны дагуу хэвлэгдсэн бол тухайн өөрчлөлт, нэмэлт тус бүрийн дугаар, хүчинтэй болох хугацаа, нислэгийн үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой мэдээллийн товч утгыг агуулсан NOTAM мэдээг зарлах, мөн уг NOTAM мэдээ нь:
 - 7.1. өөрчлөлт буюу нэмэлттэй нэгэн зэрэг хүчинтэй болно;
 - 7.2. 14 хоногийн хугацаанд хүчинтэй байна;
- 8/ AIRAC-ын тогтолцооны дагуу хэвлэгдэх мэдээлэл байхгүй тохиолдолд NIL гэсэн тэмдэглэгээтэй NOTAM мэдээг тухайн AIRAC-ын хүчин төгөлдөр болох өдрөөс 28-аас багагүй хоногийн өмнө зарлах;
- 9/ мэдээллийг НМЭ-ийн өөрчлөлт болон нэмэлтийн хүчин төгөлдөр болох өдрөөс өмнө ашиглаж эхлэхээр бол мэдээллийг NOTAM мэдээгээр зарлах.

175.63. Хэвлэгдсэн мэдээллийн алдааг залруулах

(а) Өргөдөл гаргагч нь гэрчилгээгээр олгогдсон эрхийн дагуу хэвлэсэн нисэхийн мэдээлэлд илэрсэн алдааг бүртгэх, шинжлэн шалгах, залруулах, илтгэх журмыг тогтооно.

(б) Энэ зүйлийн (а)-д заасан журамд дараах зүйлсийг тусгана:

- 1/ үйл ажиллагаанд нөлөөлөх байдлаас нь шалтгаалан алдааг хамгийн тохиромжтой аргаар залруулах;
- 2/ дахин хэвлэгдсэн мэдээлэл дэх залруулгыг тодорхой тэмдэглэх;
- 3/ алдааны эх үүсвэрийг тодорхойлж арилгах боломжит арга хэмжээ авах;

4/ зарласан мэдээлэлтэй холбогдсон зөрчлийн талаар ИНД-12-ын дагуу ИНЕГ-ын даргад мэдэгдэх.

175.65. Бүртгэл

(а) Өргөдөл гаргагч нь Үйл ажиллагааны заавартаа тусгагдсан эрхлэх НМҮ-нд шаардлагатай бүртгэлийг хөтлөх, индексжүүлэх, хадгалах, шинэчлэх, устгах журмыг тогтооно.

(б) Энэ зүйлийн (а)-д заасан журамд дараах зүйлсийг тусгана:

- 1/ хүлээн авсан болон түгээсэн бүх нисэхийн мэдээллийн бүртгэл бүр дэс дугаар, огноотой байх ба түүнд холбогдолтой нэмэлт мэдээллүүдийг үүнтэй ижил байдлаар бүртгэж баталгаажуулах;
- 2/ нисэхийн мэдээллийг шалгах, боловсруулах, хэвлэх ажлыг хариуцсан ажилтан тус бүр бүртгэл хөтлөх
- 3/ энэ дүрмийн 175.63 зүйлд заасан журмын дагуу алдааг залруулсан тохиолдол бүрт бүртгэл хөтлөх;
- 4/ энэ дүрмийн 175.67 зүйлд заасан шаардлагын дагуу байгууллагадаа явуулсан дотоод чанар хангалтын дүн шинжилгээ бүрт бүртгэл хөтлөх;
- 5/ бүх бүртгэлүүд нь гаргацтай, засваргүй байх;
- 6/ NOTAM мэдээ, НМЭ-ийн нэмэлт, Нисэхийн мэдээллийн цуврал (цаашид НМЦ гэх)-ын бүртгэлийг цуцалсанаасаа хойш 30-аас доошгүй хоног, НМЭ болон нислэгийн зургуудын бүртгэлийг 5-аас доошгүй жилийн хугацаанд хадгалах.

175.67. Дотоод чанарын хангалт

(а) Өргөдөл гаргагч нь энэ дүрмийн 175.59, 175.61 зүйлд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх шат бүрт чанарын удирдлага гүйцэтгэхэд шаардлагатай журам, үйл явц, нөөцийг багтаасан, зөв зохион байгуулалттай чанарын тогтолцоог нэвтрүүлнэ.

(б) Энэ зүйлийн (а)-гийн дагуу нэвтрүүлэх чанарын тогтолцоо нь Олон улсын стандартчиллын байгууллага (ISO)-ын чанар хангалтын 9000 бүлэг стандарт шаардлагыг хангаж холбогдох байгууллагаас гэрчилгээжсэн байвал зохино.

(в) Өргөдөл гаргагчийн чанарын тогтолцооны хэрэгжилтийг аудитаар тогтоох ба аудитаар залруулах шаардлагатай үл тохирол илэрвэл түүний шалтгааныг тогтоож, тохирох арга хэмжээг авна. Аудитын бүх дүгнэлт болон үл тохирлыг залруулах арга хэмжээнүүд нь баримттай, зохих бүртгэлтэй байна.

(г) Өргөдөл гаргагч нь энэ дүрмийн 175.51 зүйлийн (а) хэсгийн 3-т заасан ажилтнуудын мэргэжлийн мэдлэг ба ур чадварыг бататгахын тулд анхан болон давтан шалгалт авч, үнэлэн зохих бүртгэлийг хөтөлнө. Давтан шалгалт нь ажилтнуудын мэргэжлийн мэдлэг ба ур чадварыг тогтоох, дутагдлыг залруулахад оршино.

(д) Өргөдөл гаргагч нь Үйл ажиллагааны зааварт тусгагдсан эрхлэх НМҮ-ний дотоод чанар хангалтын журмыг тогтооно.

(е) Энэ зүйлийн (д) хэсэгт заасан журамд дараах зүйлсийг тусгасан байна:

- 1/ өргөдөл гаргагчийн хүрэхээр зорьж буй чанарын түвшин;
- 2/ дотоод аудит хийх түвшин, давтамж болон түүнийг гүйцэтгэх ажилтан;
- 3/ дотоод аудитыг дүгнэх чанар хангалт хариуцсан ажилтны үүрэг, хариуцлага;

- 4/ дотоод аудитын үр дүнг бүртгэх болон түүнийг удирдах албан тушаалтанд илтгэх үйл ажиллагаа;
- 5/ алдаа, зөрчил болон гомдол гэх мэт чанарын үзүүлэлтүүдийг тогтоох, зохицуулах арга хэлбэр;
- 6/ дотоод аудитаар илэрсэн аливаа дутагдлыг залруулах арга;
- 7/ дотоод аудитын бүх үйл явцын баримтжуулалтад тавигдах шаардлага;
- 8/ аливаа өгөгдлийг хэвлэх, шинэчлэх эсхүл ашиглах явцад илэрсэн үл тохиролыг залруулахын тулд тухайн нисэхийн өгөгдлийн эх сурвалжийг үйл явцын бүх шатуудад мөшгөх боломжтой байлгах зохицуулалт;
- 9/ нисэхийн мэдээлэл/өгөгдлийг энэхүү дүрмийн хавсралтад заасан өгөгдлийн чанарын шаардлага (нарийвчлалын хэмжээ, зөвшөөрөгдөх хэмжээ, бүрэн бүтэн байдал)-д нийцүүлэх болон өгөгдлийн мөшгөх боломжийг хангах зорилгоор шалгаж батлах, баталгаажуулах ажиллагаа;
- 10/ нисэхийн өгөгдлийг ашиглахаар төлөвлөсөн хугацааны хэрэгжилт болон тогтоосон өдрүүдэд мэдээллийг түгээж буй эсэхэд тавих хяналт;

(ж) Чанар хангалт хариуцсан удирдах ажилтан нь хэвлэсэн нисэхийн мэдээллийн нийцэл, үнэн зөв, маягт, загвар, цаг хугацаа, түгээсэн байдлын талаар байгууллагын удирдах албан тушаалтантай шууд харьцах эрхтэй.

175.69. Байгууллагын үйл ажиллагааны заавар

(а) Өргөдөл гаргагч нь дараах баримт бичгийг агуулсан Үйл ажиллагааны зааврыг ИНЕГ-ын даргад хүргүүлнэ.

- 1/ үйл ажиллагааны заавар болон түүнд орсон журам, зааврыг энэ дүрэмтэй нийцэж боловсруулагдсан бөгөөд түүнийг тасралтгүй хэрэгжүүлж, мөрдөгдөх талаар байгууллагын удирдах албан тушаалтны бичгээр гаргасан батламж;
- 2/ энэ дүрмийн 175.51 зүйлийн (а) хэсгийн 1/, 2/-т заасан удирдах ажилтнуудын нэрс, албан тушаал;
- 3/ энэ дүрмийн 175.51 зүйлийн (а) хэсгийн 2/-т заасан ажилтнуудын өөрийн байгууллагыг төлөөлөн ИНЕГ-ын даргатай шууд харьцах чиглэл, тэдний хүлээх үүрэг хариуцлагууд;
- 4/ энэ зүйлийн (а) хэсгийн 2/-т заасан ажилтнуудын үүрэг, хариуцлагын холбоосыг харуулсан бүдүүвч;
- 5/ энэ зүйлийн (а) хэсгийн 6/-д заасан НМҮ-г эрхлэн явуулах ажилтнуудын үйл ажиллагааны зохион байгуулалтын бүтэц;
- 6/ гэрчилгээнд тусгах НМҮ-ний жагсаалт;
- 7/ энэ дүрмийн 175.55 зүйлд заасан НӨМҮ-ний газарзүйн бүс, аэродромууд ба тэдгээрээс эхлэх агаарын замууд;
- 8/ энэ дүрмийн 175.103 зүйлийн (б) хэсгийн 1/ болон 175.105 зүйлийн (а) хэсгийн 1/-ийн дагуу байгуулагдсан нэгжүүдийн байрлал болон хаягийн жагсаалт;
- 9/ энэ дүрмийн 175.57 зүйлийн (а) хэсгийн 1/-д заасны дагуу хэвлэх нисэхийн мэдээллийн маягт болон загвар;
- 10/ НМҮ-ний үйл ажиллагаанд шаардагдах дараах журмууд:
 - 10.1. ажилтныг сонгон шалгаруулах, сургах талаар;
 - 10.2. ажилтны ур чадварын талаар;
 - 10.3. баримт бичгийн хяналтын талаар;
 - 10.4. мэдээлэл цуглуулах талаар;
 - 10.5. нисэхийн мэдээлэл хэвлэх талаар;

- 10.6. хэвлэгдсэн мэдээллийн алдааг залруулах талаар;
 - 10.7. бүртгэлийг цуглуулах, индексжүүлэх, хадгалах, шинэчлэх, устгах талаар;
 - 10.8. дотоод чанар хангалтын талаар;
 - 10.9. онцгой нөхцөл байдлын үед авах арга хэмжээний талаар.
- 11/ үйл ажиллагааны зааврыг хянах, өөрчлөх болон тараах журам.

В БҮЛЭГ. ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

175.101. Ерөнхий шаардлага

(а) Гэрчилгээ эзэмшигч нь дараах үндсэн шаардлагыг биелүүлнэ:

- 1/ Үйл ажиллагааны зааврын хүчин төгөлдөр, нэгээс доошгүй хувийг үйл ажиллагаа эрхлэх нэгж бүрт байлгах;
- 2/ Үйл ажиллагааны зааварт тусгагдсан журам, стандартуудыг мөрдөж ажиллах;
- 3/ ажил үүргээ гүйцэтгэхэд шаардагдах Үйл ажиллагааны зааврын зохих хэсгүүдийг тухайн ажилтны ажлын байранд бэлэн байлгах;
- 4/ энэ дүрмийн Б бүлэгт тавигдсан стандарт, шаардлагыг байнга мөрдөж ажиллах;
- 5/ байгууллагын хаяг болон телефон утас, факсын дугаар зэрэг харилцах хаягт өөрчлөлт орохоор бол ИНЕГ-н даргад нэн даруй мэдэгдэх;
- 6/ НМҮБ-ыг зохион байгуулах болон нисэхийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, түгээх үйл ажиллагаанд хүний хүчин зүйлийн зарчмуудыг тооцох;
- 7/ НМҮ-ний автомат системийн мэдээллийн санд чанарын шаардлага хангасан нисэхийн мэдээлэл/өгөгдлийг цаг хугацаанд нь оруулж байх.

175.103. Нисэхийн мэдээллийн эмхтгэлийн үйлчилгээ

(а) НМҮ-ний НМЭ-ийн төрлөөр гэрчилгээ эзэмшигч нь дараах бүтээгдэхүүнийг хэвлэх үүрэгтэй:

- 1/ энэ дүрмийн Г Бүлгийн дагуу Монгол Улсын НМЭ-ийг;
- 2/ энэ дүрмийн 175.155 зүйлд заасны дагуу НМЭ-ийн өөрчлөлтийг;
- 3/ 3 сар буюу түүнээс дээш хугацаатай түр шинж чанартай болон 3 сараас бага хугацаатай, их хэмжээний текст, эсхүл зураг агуулсан мэдээллийг энэ дүрмийн 175.157 зүйлийн дагуу НМЭ-ийн нэмэлтээр;
- 4/ энэ дүрмийн Д Бүлгийн дагуу НМЦ-ыг.

(б) Гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (а) хэсэгт дурдсан үйл ажиллагаанаас гадна:

- 1/ бусад улсын НМҮБ-тай NOTAM мэдээнээс бусад нисэхийн мэдээллийн нэгдсэн багцын элементийг шууд солилцох нэгжийг томилох;
- 2/ ICAO-ын гишүүн улсын НМҮБ-тай харилцан тохиролцсоны үндсэн дээр, нисэхийн мэдээллийн нэгдсэн багцын элементийг үнэгүй солилцох, төлбөртэй үйлчлэх нөхцлийг бүрдүүлэх;
- 3/ ICAO-ын гишүүн бус улстай нисэхийн мэдээллийн нэгдсэн багцын элементүүд, агаарын навигацийн бичиг баримт, хууль эрх зүйн баримт бичгүүдийг цаасан болон электрон хэлбэрээр солилцох шаардлага гарсан тохиолдолд тухайн улстай гэрээ байгуулах.
- 4/ Монгол Улсын НМЭ, түүний өөрчлөлт, НМЭ-ийн нэмэлт, нислэгийн зургийг энэ дүрмийн 175.61-р зүйлийн (в) хэсгийн 3/-ын дагуу түгээх тогтолцоог бүрдүүлэх;
- 5/ НМЭ-д орох нислэгийн зургийг холбогдох зургийн зааварт нийцүүлэх;

- 6/ энэ дүрмийн 175.59 зүйлд заасны дагуу хүлээн авсан, NOTAM мэдээгээр зарлагдахаас бусад нисэхийн мэдээллийг зохицуулж нисэхийн мэдээллийн нэгдсэн багцын тохирох элементэд хуваарилна.

175.105. NOTAM мэдээний үйлчилгээ

(а) Нисэхийн мэдээллийн үйлчилгээний NOTAM мэдээний төрлөөр гэрчилгээ эзэмшигч нь дараах үүргийг хэрэгжүүлнэ:

- 1/ Монгол Улсын олон улсын NOTAM -ын нэгжийг томилно;
- 2/ олон улсын NOTAM -ын нэгж нь 24 цагийн турш үйл ажиллагаа явуулна;
- 3/ бусад олон улсын NOTAM -ын нэгжтэй харилцан зөвшилцсөний үндсэн дээр NOTAM мэдээ солилцоно;
- 4/ энэ дүрмийн 175.59 зүйлд заасны дагуу хүлээн авсан мэдээллийг NOTAM мэдээгээр зарлах шаардлагатай үед E бүлгийн дагуу яаралтай боловсруулан тараана;
- 5/ хүчинтэй NOTAM-ын хяналтын жагсаалтуудын хоорондын зай нь нэг сараас илүүгүй байна.

175.107. Нислэгийн өмнөх мэдээллийн үйлчилгээ

(а) НМҮ-ний Нислэгийн өмнөх мэдээлэл (цаашид НӨМ гэх)-ийн төрлөөр гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээнд тусгагдсан аэродромд НӨМҮ үзүүлэх нэгжийг томилж, нислэгийн үйл ажиллагаанд оролцогч ажилтан, нисэх багийг дараах нисэхийн мэдээллээр хангана. Үүнд:

- 1/ агаарын навигацийн аюулгүй байдал, тогтмолжилт, үр ашигтай байдалд чухал шаардлагатай мэдээлэл;
- 2/ тухайн аэродромоос эхлэлтэй нислэгийн маршрутын хэсэгт хамааралтай мэдээлэл.

(б) Энэ зүйлийн (а) хэсэгт заасан нисэхийн мэдээлэл нь дараах агуулгатай байна:

- 1/ NOTAM мэдээ болон бусад чухал шаардлагатай мэдээллийг энгийн бичвэр хэлбэрээр агуулсан НӨМ-ийн товхимол;
- 2/ нисэхийн мэдээллийн нэгдсэн багцын холбогдох элемент;
- 3/ холбогдох газрын болон нислэгийн зураг;
- 4/ нисэн гарах аэродромд хамааралтай тухайн цаг үеийн дараах мэдээллүүд:
 - 4.1. маневрын талбай буюу түүний ойр хийж буй барилгын эсхүл засварын ажил;
 - 4.2. Хөөрч буух зурвас (цаашид ХБЗ гэх), явгалах зам (цаашид ЯЗ гэх)-ын гадаргууд гарсан эвдрэл болон маневрын талбайн тэгш бус хэсэг тэмдэглэгдсэн эсэх;
 - 4.3. ХБЗ, ЯЗ дээрх цас, мөс, ус, тэдгээрийн гүн болон гадаргуугийн үрэлтийн коэффициентэд нөлөөлөх байдал;
 - 4.4. ХБЗ, ЯЗ дээр, эсхүл тэдгээрийн хажууд цас хунгарласан буюу дагтаршсан эсэх;
 - 4.5. ЯЗ дээр, эсхүл түүний хажууд зогсож байгаа агаарын хөлөг болон өөр бусад объектын тухай;
 - 4.6. бусад түр зуурын шинж чанартай аюултай нөхцөл үүссэн эсэх;
 - 4.7. агаарын хөлгийн үйл ажиллагаанд аюултай нөхцөл үүсгэж болзошгүй шувуудын тухай;
 - 4.8. аэродромын гэрлэн систем (ойртолт, босго, ХБЗ, ЯЗ-ны гэрэл), саадын гэрэл, 4.9. маневрын талбайн ажилгүй хэсгийг анхааруулах гэрэл болон аэродромын цахилгаан хангамжийн эвдрэл гэмтэл, тогтмол бус ажиллагааны тухай;
 - 4.10. хяналтын хоёрдогч радиолокатор (SSR), автомат хамааралтай ажиглалтын систем(ADS-B, ADS-C), нислэгийн удирдагч, нисэгчийн өгөгдөлийн сүлжээний

холбоо (CPDLC), өгөгдөл дамжуулах шугамд суурилагдсан Аэродромын автомат мэдээллийн үйлчилгээ (D-ATIS), өгөгдөл дамжуулах шугамд суурьлагдсан VOLMET(D-VOLMET), радио навигацийн үйлчилгээ болон нисэхийн хэт өндөр давтамж (VHF), зурвасны дагуух алсын барааны харагдац (RVR)-ыг хэмжих ажиглалтын систем, нөөц цахилгаан хангамжуудийн эвдрэл гэмтэл, тогтмол бус ажиллагаа ба үйл ажиллагааны нөхцөл байдалд гарсан өөрчлөлт.

(в) НМҮ-ний НӨМ-ийн төрлөөр гэрчилгээ эзэмшигч нь нисэхийн тоног төхөөрөмжийн ажиллагаа болон шувуудын бөөгнөрөлийн талаар нислэгийн дараах илтгэх хуудсыг нисэх багаар бөглүүлэх нөхцлийг бүрдүүлнэ.

(г) НМҮ-ний НӨМ-ийн төрлөөр гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (в) хэсгийн дагуу агаарын навигацийн тоног төхөөрөмж эсхүл үйлчилгээний ажиллагаа, нөхцөл байдлын талаар бөглөсөн нислэгийн дараах илтгэх хуудсыг холбогдох хариуцсан байгууллагад дамжуулна.

(д) НМҮ-ний НӨМ-ийн төрлөөр гэрчилгээ эзэмшигч нь НӨМҮ үзүүлдэг аэродромын нислэгийн хөдөлгөөнтэй холбогдолтой мэдээг ICAO-ын шаардлагын дагуу гадаад орнуудын болон Монгол Улсын нислэгийн мэдээллийн районы нислэгийн мэдээллийн төв, бүсийн удирдлагын төвүүд болон бусад шаардлагатай хаягуудад AFTN-ээр дамжуулна.

(е) НӨМ-ийн автомат систем ашиглаж буй НМҮ-ний НӨМ-ийн төрлөөр гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг хангана:

- 1/ нислэгийн үйл ажиллагаанд оролцогч ажилтан, нисэх баг нь бие даан НӨМ-ийн хангалтыг авах, нислэгийн төлөвлөлт хийх автомат системтэй бол энэ зүйлийн (а), (б)-хэсэгт заасан мэдээллийг агуулсан сантай байх;
- 2/ НӨМ-ийн автомат систем нь нислэгийн өмнөх болон нисэхийн цаг уурын мэдээллийн нэгдсэн сантай бол НӨМҮ эрхлэх байгууллага болон нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага хооронд хамтран ажиллах гэрээ байгуулах;
- 3/ нислэгийн үйл ажиллагаанд оролцогч ажилтан, нисэх баг нь НӨМ-ийн автомат систем ашиглан бие даан НӨМ-ийн хангалтыг авахад шаардагдах тоног төхөөрөмж, НМҮБ-тай холбогдох утас эсхүл бусад тохиромжтой холбооны хэрэгсэлтэй байх;
- 4/ автомат системийн мэдээллийн санг тасралтгүй, цаг хугацаанд нь шинэчлэх, хадгалагдсан нисэхийн мэдээллийн чанар, хүчин төгөлдөр хугацааг шалгах;
- 5/ автомат системийн мэдээллийн сан дахь нисэхийн өгөгдлийг шаардлагатай тохиолдолд цаасан хэлбэрээр гаргадаг байх;
- 6/ автомат систем нь шаардлагатай мэдээллийг шуурхай олоход зориулсан лавлагаатай байх эсхүл ICAO-гоос тогтоосон байршил илтгэгч 4 үсгийн кодоор мэдээллийг олж авах боломжтой байх мөн хэрэглэгчийн шаардсан мэдээллийн хариуг даруй гаргадаг байх.

175.109. Гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагааны өөрчлөлт

(а) Гэрчилгээ эзэмшигч нь НМҮБ-ын үйл ажиллагаа, эрхлэх үйлчилгээ болон бүтэц зохион байгуулалтанд өөрчлөлт орсон үед тухайн өөрчлөлтийг Үйл ажиллагааны зааварт оруулан хэрэгжүүлнэ.

(б) Гэрчилгээ эзэмшигчийн Үйл ажиллагааны зааварт оруулж байгаа өөрчлөлт нь энэ дүрмийн шаардлага болон үйл ажиллагааны зааварт өөрчлөлт оруулах журамд нийцсэн байна.

(в) Гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагааны зааварт өөрчлөлт ормогц өөрчлөлтийн хувийг ИНЕГ-ын даргад өгнө.

(г) Гэрчилгээ эзэмшигчийн Үйл ажиллагааны зааварт дараах өөрчлөлтийг оруулах тохиолдолд ИНЕГ-ын даргад урьдчилан мэдэгдэж зөвшөөрөл авсан байна:

- 1/ удирдах албан тушаалтан;
- 2/ удирдах ажилтнууд;
- 3/ гэрчилгээ эзэмшигчийн эрхлэх НМҮ;
- 4/ гэрчилгээгээр олгогдсон эрхийн дагуу хэвлэгдэх нисэхийн мэдээллийн маягт, загвар болон стандартууд.

(д) ИНЕГ-ын дарга энэ зүйлийн (г) хэсэгт дурьдсан аливаа өөрчлөлтийг оруулах эсхүл мөрдөх явцад үйл ажиллагаа явуулах нөхцлийг тусгайлан тогтоож өгч болно.

(е) Гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (д) хэсэгт заасан нөхцлийг дагаж мөрдөнө.

(ж) НМҮ-ний гэрчилгээнд өөрчлөлт оруулах шаардлага гарсан тохиолдолд гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээгээ ИНЕГ-ын даргад хүргүүлнэ.

(з) Гэрчилгээ эзэмшигч нь ИНЕГ-ын даргын нисэхийн аюулгүй ажиллагаанд шаардлагатай гэж үзсэн өөрчлөлтийг үйл ажиллагааны заавартаа оруулна.

175.111. Аюулгүй ажиллагааны шалгалт ба аудит

(а) ИНЕГ-ын дарга нь иргэний нисэхийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдалыг хангахын тулд шаардлагатай гэж үзвэл байгууллага, тоног төхөөрөмж, баримт бичиг, бүртгэлдээ шалгалт хийлгэх болон аудитад хамрагдахыг гэрчилгээ эзэмшигчээс бичгээр шаардан авч болно.

(б) ИНЕГ-ын дарга нь шалгалт эсхүл аудитад хамааралтай гэж үзсэн мэдээллээр хангахыг гэрчилгээ эзэмшигчээс шаардаж болно.

Г БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН НИСЭХИЙН МЭДЭЭЛЛИЙН ЭМХТГЭЛ

175.151. Монгол Улсын НМЭ-ийн агуулга

(а) НМЭ-ийн бүтэц, агуулга, загвар нь ICAO-гийн Хавсралт 15-ын шаардлагад нийцсэн байна. Хэрэв НМЭ, эсхүл түүний хэсгийн нислэгийн явцад ашиглахад хялбар байхаар зохиогдсон, агуулгын хүснэгтийг оруулсан бол НМЭ-ийн бүтэц, хэв загварыг гэрчилгээ эзэмшигч өөрөө хийж болох ба энэ тохиолдолд ИНЕГ-ын даргаар батлуулна.

(б) Монгол Улсын НМЭ нь дараах хүчин төгөлдөр мэдээлэл, өгөгдөл болон нислэгийн зургуудыг агуулсан байна:

- 1/ Монгол Улсын агаарын навигацид тавигдах агаарын зайн шаардлага болон зохицуулалт;
- 2/ олон улсын агаарын навигацид үзүүлэх Монгол Улсын үйлчилгээ болон тоног төхөөрөмжүүд;
- 3/ Монгол Улсын нислэгийн мэдээллийн районд үзүүлж буй агаарын навигацийн үйлчилгээ, тоног төхөөрөмжүүд;

4/ ИНД-139-ийн дагуу гэрчилгээжиж үйл ажиллагаа явуулж буй аэродромд ашиглагдах байдлаас нь шалтгаалан оруулах нислэгийн зургууд:

- 4.1. Аэродромын зураг;
- 4.2. Аэродромын газрын хөдөлгөөний зураг;
- 4.3. Аэродромын саадын зураг;
- 4.4. Аэродромын газрын гадаргын болон саадын зураг (электрон);
- 4.5. Агаарын хөлгийн зогсоолын зураг;
- 4.6. Бүсийн зураг;
- 4.7. НХУ-ын ажиглалтын хамгийн бага үнэмлэхүй өндрийн зураг;
- 4.8. Хэрэглэлээр ойртолт үйлдэх зураг;
- 4.9. Нарийвчлалтай ойртолтын газрын гадаргын зураг;
- 4.10. Хэрэглэлээр нисэн ирэх стандарт зураг;
- 4.11. Хэрэглэлээр нисэн гарах стандарт зураг;
- 4.12. Ил хараагаар ойртолт үйлдэх зураг.

(в) Монгол Улсын НМЭ нь дараах тохиолдолд гэрчилгээжээгүй аэродромуудын хүчин төгөлдөр мэдээлэл, өгөгдөл болон нислэгийн зургуудыг агуулж болно:

- 1/ аэродром эзэмшигч нь НМУ-ний НМЭ-ийн төрлөөр гэрчилгээ эзэмшигчийг тухайн аэродромын шаардлагатай өгөгдөл болон мэдээллээр хангасан бол;
- 2/ аэродром эзэмшигч нь хангасан өгөгдөл болон мэдээллийн үнэн зөв, хүчин төгөлдөр байдалд хариуцлага хүлээх бол.

(г) Монгол Улсын НМЭ-ийн хэсгүүдэд дараах мэдээллүүдийг оруулсан байна:

- 1/ Монгол Улсын НМЭ-д орсон агаарын навигацийн тоног төхөөрөмж, үйлчилгээ болон журмуудад хариуцлага хүлээх гэрчилгээжсэн байгууллагуудын талаарх мэдээлэл;
- 2/ тухайн үйлчилгээ болон тоног төхөөрөмжүүдийн ашиглалтанд тавигдах ерөнхий нөхцлүүд;
- 3/ Чикагогийн конвенцийн Хавсралтуудад заасан стандарт, зөвлөмжүүдээс Монгол Улсын иргэний нисэхийн дүрэм, журмын зөрүүтэй заалтуудын талаар ИНЕГ-ын даргын гаргасан жагсаалт;
- 4/ ICAO-ын стандарт, зөвлөмж ба журмуудаар зөвшөөрсөн, сонголттойгоор хэрэгжүүлэх боломжтой үйл ажиллагааны Монгол Улсад мөрдөгдөж буй тусгай стандарт, зөвлөмж, журмын талаар.

(д) НМЭ-д орох текстэн, эсхүл хүснэгтэн мэдээллийг тохиромжтой бол бүдүүвч, зураг, диаграммаар орлуулж эсхүл давхар илэрхийлж болно.

175.153. Монгол Улсын НМЭ-д тавигдах шаардлага

(а) Монгол Улсын НМЭ нь (GEN)/Ерөнхий, (ENR)/Маршрут, (AD)/Аэродром гэсэн гурван үндсэн хэсгээс бүрдэх бөгөөд хэсэг бүр нь:

- 1/ Монгол Улсын НМЭ-ийн нэг хэсэг болохыг болон эрх бүхий байгууллагаар хэвлэгдсэн болохыг заасан байх;
- 2/ хуудасны дугаарлалт бүхий агуулгатай байх ба хуудсууд нь ойлгомжтой дугаарлагдсан байх;
- 3/ давтагдсан мэдээлэлгүй байх ба хэрэв зайлшгүй давтагдах шаардлагатай бол мэдээллүүд нь өөр хоорондоо зөрүүгүй байх;

- 4/ салдаг хуудсуудтай байх ба хуудас бүрт мэдээллийн хүчинтэй болох эсхүл хэвлэгдсэн огноо байх. Огноог он, нэрээр бичсэн сар, өдрөөр тэмдэглэнэ;
- 5/ НМЭ нь түүнд өөрчлөлт оруулснаар шинэчлэгдэх ба өөрчлөлт оруулах тодорхой хугацаа тогтоосон бол түүнийг НМЭ-д оруулах;
- 6/ Дор дурдсан агуулгатай хяналтын жагсаалттай байна.
 - 6.1. хуудас бүрийн хүчин төгөлдөр огноо болон хуудасны дугаартай;
 - 6.2. НМЭ-ийн өөрчлөлт бүртэй хамт хэвлэгдэнэ;
 - 6.3. аль хэсэгт хамаарахыг заана;
 - 6.4. энэ зүйлийн (а) хэсгийн 4/-т заасны дагуу огноотой байх ба хуудасны дугаартай хэвлэгдэнэ.

(б) НМЭ-ийн хуудас нь дараах мэдээллийг агуулсан байна. Үүнд:

- 1/ тухайн НМЭ-ийн салшгүй хэсэг болохыг заасан тэмдэглэгээтэй байх;
- 2/ тухайн НМЭ-ийг эрхлэн гаргаж буй улсын эсхүл байгууллагын таних тэмдэг, тэмдэглэгээтэй байх;
- 3/ тухайн хуудасны дугаар, огноо, зургийн нэрийг тусгасан байх,
- 4/ баталгаажуулагдаагүй мэдээллийн үнэн зөв байх магадлалын түвшинг тодорхой заасан байх;
- 5/ хуудасны хэмжээ 210 x 297 мм-с томгүй байх ба хэрэв бусад хуудсуудаас том хэмжээтэй хуудас оруулахаар бол ижил хэмжээтэй байхаар нугална.

175.155. НМЭ-ийн өөрчлөлтөнд тавигдах шаардлага

(а) НМЭ-ийн өөрчлөлт бүр нь дараах шаардлагыг хангасан байна:

- 1/ НМЭ-д оруулах тогтмол шинж чанартай өөрчлөлтүүдийг багтаасан байна.
- 2/ хэвлэгдсэн мэдээлэлд орсон өөрчлөлт болон шинэ мэдээллүүдийн ялгааг тодорхой заасан тэмдэглэгээ эсхүл тайлбартай байх;
- 3/ хуанлийн жилд үндэслэсэн дараалсан дугаартай байх;

(б) нүүр хуудастай байх бөгөөд тухайн өөрчлөлтийн товч утга, хэвлэгдсэн огноо, хүчинтэй болох огноо зэргийг тусгана.

(в) AIRAC-ын тогтолцооны дагуу хэвлэгдсэн НМЭ-ийн өөрчлөлтийн хуудас бүр нь хүчинтэй болох огноотой байна.

(г) НМЭ-ийн өөрчлөлт нь нисэхийн мэдээллийн нэгдсэн багцын элементийг агуулж байвал тухайн элементийн дугаарыг НМЭ-ийн өөрчлөлтийн нүүр хуудсанд тэмдэглэнэ.

(д) Хэрэв НМЭ-ийн өөрчлөлт нь тогтоогдсон үечлэлд хэвлэгдээгүй тохиолдолд хүчинтэй NOTAM-ын жагсаалтаар NIL гэсэн тэмдэглэгээ хийж түгээнэ.

175.157. НМЭ-ийн нэмэлтэнд тавигдах шаардлага

(а) НМЭ-ийн нэмэлт бүр нь хуанлийн жилд үндэслэсэн дараалсан дугаартай байна.

(б) НМЭ-н нэмэлтийг зөвхөн шар өнгийн хуудсан дээр хэвлэх ба НМЭ-ийн эхэнд хадгалагдана.

(в) НМЭ-ийн нэмэлтийн аль нэг хэсэгт хүчинтэй мэдээлэл агуулагдаж байвал тухайн нэмэлт нь НМЭ-д хавсаргагдсан хэвээр байна.

(г) Хэрэв НМЭ-ийн нэмэлтээр NOTAM мэдээг орлуулж байгаа бол тухайн NOTAM мэдээний дугаарыг НМЭ-ийн нэмэлтэд оруулна.

(д) Хүчинтэй НМЭ-ийн нэмэлтийн хяналтын жагсаалтыг нэг сараас илүүгүй хугацаанд, эсхүл НМЭ-ийн нэмэлттэй хамт хэвлэн түгээнэ.

Д БҮЛЭГ. НИСЭХИЙН МЭДЭЭЛЛИЙН ЦУВРАЛ

175.201. НМЦ-ын агуулга

(а) NOTAM мэдээ үүсгэх болон НМЭ-д оруулах шаардлагагүй, нисэхийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагаа, агаарын навигаци, техник, захиргаа, хууль зүйн холбогдолтой дараах мэдээллийг НМЦ-аар гаргана.

- 1/ агаарын навигацийн журам, үйлчилгээ болон тоног төхөөрөмжид орох томоохон өөрчлөлтийн урьдчилсан мэдээлэл;
- 2/ шинэ навигацийн тогтолцоо нэвтрүүлэх талаарх урьдчилсан мэдээлэл;
- 3/ нислэгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах шалгалтын үр дүнд бий болсон нислэгийн аюулгүй ажиллагаанд хамааралтай чухал мэдээлэл;
- 4/ олон улсын иргэний нисэхийг хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалахтай холбогдсон зохицуулалтын мэдээлэл;
- 5/ нисэгч нарт өгөх шаардлагатай эрүүл мэндийн талаарх зөвлөгөө;
- 6/ биет аюулаас зайлсхийх талаар нисэгч нарт зориулсан анхааруулга;
- 7/ нислэгийн үйл ажиллагаанд нөлөөлөх цаг агаарын тодорхой үзэгдэл;
- 8/ нислэг үйлдэхэд нөлөөлөх шинэ аюулын талаарх мэдээлэл;
- 9/ хориотой зүйлсийг агаараар тээвэрлэхтэй холбоотой зохицуулалтууд;
- 10/ нисэх багийг гэрчилгээжүүлэх зарчим;
- 11/ нисэхийн ажилтны сургалт;
- 12/ тоног төхөөрөмжийн ашиглалт, техник үйлчилгээний зөвлөгөө;
- 13/ шинэчлэгдсэн, эсхүл шинээр гаргах гэж байгаа нислэгийн зургуудын хүчин төгөлдөр, эсхүл төлөвлөгдөж буй хэвлэлийн талаарх мэдээлэл;
- 14/ агаарын хөлөгт суурилуулах шаардлагатай холбооны тоноглолын талаарх мэдээлэл;
- 15/ дуу чимээ бууруулахтай холбоотой тайлбар мэдээлэл;
- 16/ нислэгт тэнцэх чадварын талаарх тусгай удирдамж;
- 17/ NOTAM мэдээний серийн өөрчлөлт, НМЭ-ийн шинэ хэвлэл гаргах эсхүл агуулга, хамрах хүрээ, загварт орох томоохон өөрчлөлт;
- 18/ цасны төлөвлөгөөний талаарх урьдчилсан мэдээлэл;
- 19/ ижил төстэй бусад мэдээлэл.

175.203. НМЦ-д тавигдах шаардлага

(а) НМЦ бүрийг хуанлийн жилд үндэслэсэн дараалсан дугаартай гаргах ба хэвлэмэл байдлаар түгээнэ.

(б) Үүсгэгч байгууллага нь олон улсад түгээх НМЦ-ыг сонгож НМЭ-тэй адил тараана.

(в) НМЦ нь нэгээс илүү сериэр тараагдах тохиолдолд сери бүр нь ялгагдах үсгэн тэмдэглэгээтэй байна.

(г) Хүчинтэй НМЦ-ийн хяналтын жагсаалтыг хамгийн багадаа жилд нэгээс доошгүй удаа НМЦ-аар хэвлэн түгээнэ.

Е БҮЛЭГ. NOTAM МЭДЭЭ

175.251. NOTAM мэдээний агуулга

(а) NOTAM мэдээ болон цасны NOTAM мэдээний маягтын агуулга, загвар нь ICAO-ын Хавсралт 15-ын шаардлагад нийцсэн байна.

(б) Богино хугацаатай (3 сараас доош), эсхүл үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой тогтмол, эсхүл урт хугацаатай түр шинж чанартай дараах мэдээллүүдийг яаралтай зарлах тохиолдолд их хэмжээний текст, эсхүл зураг агуулаагүй бол NOTAM мэдээгээр зарлана. Үүнд:

- 1/ аэродром, вертодром болон ХБЗ-уудыг нээх, хаах, эсхүл тэдгээрийн үйл ажиллагаанд орсон чухал өөрчлөлтүүд;
- 2/ нисэхийн үйлчилгээ (AGA, AIS, ATS, COM, MET, SAR г.м)-нүүдийг нэвтрүүлэх, татан буулгах болон тэдгээрийн үйл ажиллагаанд орсон чухал өөрчлөлтүүд;
- 3/ агаарын навигаци болон агаар-газрын холбооны үйлчилгээг бий болгох, татан буулгах болон түүний горимд орсон чухал өөрчлөлтүүд. Үүнд: үйл ажиллагааны тасалдал, хэвийн болох, давтамж өөрчлөгдөх, үйлчилгээний цагийн хуваарь өөрчлөгдөх, дуудлага, чиглэл өөрчлөгдөх, байршил өөрчлөгдөх, 50% болон түүнээс дээш хэмжээгээр чадал ихсэх буюу багасах, өргөн нэвтрүүлгийн хуваарь болон агуулгын бүтэц өөрчлөгдөх, агаарын навигацийн болон агаар-газар холбооны үйлчилгээний үйл ажиллагааны тогтмол бус, найдвартай бус байдал;
- 4/ ил харааны тоног төхөөрөмжүүдийг суурьлуулах, ашиглалтаас гаргах эсхүл тэдгээрт орсон чухал өөрчлөлтүүд;
- 5/ аэродромын гэрлэн системийн үндсэн хэсгийн ажиллагаа тасалдах, хэвийн болох;
- 6/ агаарын навигацийн үйлчилгээнд мөрдөх журмыг тогтоох, цуцлах эсхүл тэдгээрт орсон чухал өөрчлөлтүүд;
- 7/ маневрын талбайд саад, эвдрэл гарах, эсхүл түүнийг засварлах;
- 8/ түлш, тос, хүчилтөрөгчийн бэлэн байдал, түүний хязгаарлалт ба өөрчлөлтүүд;
- 9/ эрэн хайх, авран туслах үйлчилгээ болон түүний төхөөрөмжүүдийн бэлэн байдалд гарсан чухал өөрчлөлтүүд;
- 10/ агаарын навигацид нөлөөлөх саадыг тэмдэглэх гэрэл суурьлуулах, ашиглалтаас гаргах эсхүл хэвийн болох;
- 11/ яаралтай арга хэмжээ авах шаардлагаар үйл ажиллагаанд өөрчлөлт орох. Жишээ: эрэн хайх, авран туслах (SAR) үйл ажиллагаанд зориулсан хориотой бүс тогтоох;
- 12/ агаарын навигацид нөлөөлөх аюултай байдал үүсэх (саад, цэргийн сургуульлалт, үзүүлэх тоглолт, уралдаан, зарлагдсан бүсээс гадуурх шүхрийн буулт г. м.);
- 13/ нислэгийн зурвас болон хөөрөх, өндөр авах, хоёрдугаар тойрогт гарах, ойртолт үйлдэх бүсэд агаарын навигацид нөлөөлөх саад босгох, буулгах эсхүл өөрчлөх;
- 14/ хориотой, хязгаарлагдсан, аюултай бүсүүдийг тогтоох, үйл ажиллагааг зогсоох болон тэдгээрийн нөхцөл байдалд гарах өөрчлөлт;
- 15/ Халдлагад өртөж болзошгүй бөгөөд 121.5 мгц-г байнга сонсож байх шаардлагатай бүс, агаарын зам, тэдгээрийн хэсгүүдийг тогтоох, татан буулгах.

- 16/ байршил илтгэгч 4 үсгийн кодыг үүсгэх, хүчингүй болгох болон өөрчлөх;
- 17/ аэродромын авран туслах, гал унтраах хамгаалалтын түвшинд орсон чухал өөрчлөлт. Аэродромын гал унтраах зэрэглэлд өөрчлөлт орсон нөхцөлд зэрэглэлийн өөрчлөлтийг тодорхой тусгасан NOTAM зарлана;
- 18/ хөдөлгөөний талбайд цас, мөс, шалбааг, тогтоол усны улмаас аюултай нөхцөл үүсэх, түүнийг арилгах эсхүл түүнд гарсан өөрчлөлт;
- 19/ урьдчилан сэргийлэх тариа болон хөл хорионы талаар тавигдсан шаардлагад тахал гарсны улмаас өөрчлөлт орох;
- 20/ нарны сансрын радиацийн урьдчилсан мэдээ хүлээн авсан үед;
- 21/ атомын болон химийн ослын улмаас радио идэвхит материал, эсхүл хорт химийн бодисын агаар мандал дахь тархалт, түүний хөдөлгөөний чиглэл, осол гарсан байршил болон огноо, хамрагдаж болзошгүй нислэгийн өндөр, агаарын зам, түүний хэсэг;
- 22/ хүмүүнлэгийн тусламжийн зорилготой үйл ажиллагааны чиглэлээр гарах агаарын навигацид нөлөөлөх журам болон хязгаарлалтууд. Тухайлбал: Нэгдсэн үндэстний байгууллагын шугамаар;
- 23/ гэнэтийн нөхцөл байдлын улмаас НХҮ болон холбогдох туслах үйлчилгээ хэсэгчлэн болон бүхэлдээ тасарсан тохиолдолд авах түр хугацааны арга хэмжээ;
- 24/ агаарын хөлгийн үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй бусад нөхцөл бий болох.

(в) NOTAM мэдээгээр дараах мэдээлэл зарлагдахгүй.

- 1/ агаарын хөлгийн хөдөлгөөнд нөлөөлөхгүйгээр перрон болон ЯЗ дээр засварын ажил хийх;
- 2/ шаардлагатай тохиолдолд ХБЗ-ыг чөлөөлөх боломжтой эсхүл агаарын хөлгөөр ХБЗ ашиглан үйл ажиллагаагаа явуулах боломжтой бол ХБЗ дээр будган тэмдэглээний ажил хийх;
- 3/ аэродром/вертодромын ойр орчимд агаарын хөлгийн аюулгүй ажиллагаанд нөлөөлөхгүй түр зуурын саад босгох;
- 4/ агаарын хөлгийн аюулгүй ажиллагаанд шууд нөлөөлөхгүй бол аэродромын гэрлэн төхөөрөмжийн зарим хэсэг ажиллагаагүй болох;
- 5/ орлуулж ашиглах тодорхой нөөц давтамжтай, тэр нь хэвийн ажиллаж байгаа бол агаар-газрын холбооны төхөөрөмж нь түр хугацаагаар ажиллагаагүй болох;
- 6/ перрон дээрх агаарын хөлгийг хөтлөх үйлчилгээ болон замын хөдөлгөөний зохицуулалт нь хангалтгүй бол;
- 7/ аэродромын хөдөлгөөний талбайн тэмдэг, тэмдэглэгээ ашиглалтын шаардлага хангахгүй болох;
- 8/ хяналтгүй агаарын зайд ИХНД-ээр, хяналттай агаарын зайн аюултай, хориотой эсхүл тусгайлан зарлагдсан бүсэд шүхрийн буулт хийх бол;
- 9/ ижил төстэй түр зуурын бусад мэдээлэл.

(г) Холбооны үйлчилгээ, эсхүл агаарын навигацийн тоног төхөөрөмжийн татгалзлын талаар NOTAM мэдээ зарлаж байгаа үед тухайн үйлчилгээ, тоног төхөөрөмжийн хэвийн болох тооцоот хугацааг оруулна.

175.253. NOTAM мэдээнд тавигдах шаардлага

(а) NOTAM мэдээний бичвэр нь ICAO-ын NOTAM мэдээний кодонд зориулан тогтоосон товчлогдсон хэллэг, давтамж, дуудлага, нэр, заагч, тодорхойлогч, ICAO-ын товчлол, байршил илтгэгч 4 үсгийн код болон энгийн текстээс бүрдэх ба англи хэлээр бичигдэнэ.

(б) NOTAM мэдээний сери бүр нь ялгагдах үсгэн тэмдэглэгээтэй байна.

(в) NOTAM мэдээ нь хуанлийн жилд үндэслэсэн дараалсан дугаартай байна.

(г) NOTAM мэдээг зөвхөн нэг зүйлийн талаар товч, тодорхой, өөр баримт бичгээс лавлаж харах шаардлагагүй байхаар боловсруулна.

(д) NOTAM мэдээ нь НМЭ-н өөрчлөлт, нэмэлттэй холбоотой мэдээллийг агуулж байвал тухайн НМЭ-н хэсэг болон түүний нэмэлтийн лавлагааг NOTAM мэдээнд оруулна.

(е) NOTAM мэдээ нь өмнөх мэдээг цуцалж, эсхүл орлуулж байгаа бол өмнөх мэдээний сери, дугаарыг тодорхой зааж өгнө. Цуцалж, эсхүл орлуулж байгаа NOTAM мэдээний зүйл, байршил илтгэгч 4 үсгийн код нь өмнөх NOTAM мэдээтэй ижил байх ба нэг NOTAM мэдээгээр зөвхөн нэг NOTAM мэдээг цуцалж, эсхүл орлуулж болно.

(ж) NOTAM мэдээ нь алдаатай зарлагдсан тохиолдолд тухайн мэдээг орлуулж эсхүл цуцалж шинэ NOTAM мэдээ зарлана.

(з) NOTAM мэдээний текстэнд орсон байршил илтгэгч 4 үсгийн код нь ICAO-аас батлагдсан байх ба түүнийг товчилсон хэлбэрээр ашиглаж болохгүй.

(и) Тухайн газар нь байршил илтгэгч 4 үсгийн кодгүй бол NOTAM мэдээний текстэнд газрын нэрийг энэ дүрмийн 175.61 зүйлийн (б) хэсгийн 9/-д заасны дагуу оруулна.

(к) Энэ дүрмийн 175.105 зүйлийн 5/-д заасан хүчинтэй NOTAM-ын хяналтын жагсаалт нь:

- 1/ хамгийн сүүлд хэвлэгдсэн НМЭ-ийн өөрчлөлт, түүний нэмэлт болон олон улсад тараагдсан НМЦ-ын дугааруудыг агуулна;
- 2/ дурьдаж байгаа NOTAM мэдээнүүдтэй ижил серитэй байх ба бусад NOTAM мэдээнээс ялгагдах "CHECKLIST" гэсэн тэмдэглэгээтэй байна.

(л) Сүүлийн НМЭ-ийн өөрчлөлт болон НМЦ, НМЭ-ийн нэмэлтийн хяналтын жагсаалтуудыг агуулсан хүчинтэй NOTAM-ын жагсаалтыг сар бүр энгийн бичвэрээр хэвлэн нисэхийн мэдээллийн нэгдсэн багцын хэрэглэгчдэд түгээнэ.

175.255. NOTAM мэдээг түгээх

(а) NOTAM мэдээ бүрийг дараах байдлаар түгээнэ:

- 1/ боломжтой бол AFTN сувгаар нэг мэдээ хэлбэрээр;
- 2/ тухайн NOTAM мэдээний серид хамааралтай багц хаягуудаар;
- 3/ ICAO-ын холбооны журмуудын холбогдох заалтуудад нийцсэн байхаар.

(б) NOTAM мэдээг түгээх үндсэн суваг нь AFTN байна.

(в) Энэ дүрмийн 175.105 зүйлийн 3/ дахь заалтын дагуу NOTAM мэдээ солилцдог байгууллага, газруудад AFTN-ээс өөр хэрэгслээр NOTAM мэдээ илгээх тохиолдолд NOTAM мэдээний өмнө тухайн мэдээг илгээсэн хугацаа (өдөр, цаг, минут бүхий 6 оронтой тоо) болон мэдээ илгээгчийн AFTN хаягийг тусгасан байна.

(г) Энэ дүрмийн 175.105 зүйлийн 3/-т заасан бусад олон улсын NOTAM нэгжүүдэд NOTAM мэдээг тараах тогтолцоог бүрдүүлж түүний дагуу тараана.

(д) Үүсгэгч байгууллага нь олон улсад тараах NOTAM мэдээг сонгоно.

---oOo---

ХАВСРАЛТ 1

НИСЭХИЙН МЭДЭЭЛЭЛ/ӨГӨГДЛИЙН ШААРДЛАГА

Нисэхийн мэдээлэл/өгөгдөлийн чанарын шаардлага нь нарийвчлалын хэмжээ, зөвшөөрөгдөх хэмжээ болон бүрэн бүтэн байдлаас бүрдэх ба энэхүү хавсралтанд заасны дагуу байна:

(а) Нарийвчлалын хэмжээ дараах 3 төрөл байна:

- 1/ *хэмжигдсэн цэг* (ХБЗ-ын босго, навигацийн тоног төхөөрөмжийн байршил г.м.)
- 2/ *тооцоологдсон цэг* (хэмжигдсэн цэгээс математик аргаар тооцоолсон агаар дахь цэг/хяналтын цэг)
- 3/ *зарлагдсан цэг* (нислэгийн мэдээллийн районы хилийн цэг)

(б) Өгөгдлийн бүрэн бүтэн байдал нь дараах түвшин болон ангилалтай байна:

- 1/ *эрсдэлтэй өгөгдөл* (бүрэн бүтэн байдлын түвшин 1×10^{-8}): алдаатай эрсдэлтэй өгөгдлийг ашиглах нь агаарын хөлгийн нислэгийн болон буултын үед ноцтой нөлөөлж осолд хүргэх өндөр магадлалтай;
- 2/ *чухал өгөгдөл* (бүрэн бүтэн байдлын түвшин 1×10^{-5}): алдаатай чухал өгөгдлийг ашиглах нь агаарын хөлгийн нислэгийн болон буултын үед ноцтой нөлөөлж осолд хүргэх бага магадлалтай;
- 3/ *энгийн өгөгдөл* (бүрэн бүтэн байдлын түвшин 1×10^{-3}): алдаатай энгийн өгөгдлийг ашиглах нь агаарын хөлгийн нислэгийн болон буултын үед ноцтой нөлөөлж осолд хүргэх маш бага магадлалтай;
 - 3.1. электрон нисэхийн өгөгдлийн хамгаалалт нь хадгалах болон дамжуулах үед Циклийн үлдэгдэл шалгалт (CRC)-аар бүрэн хянагдана. Эрсдэлтэй болон чухал нисэхийн өгөгдлийн бүрэн бүтэн байдлын түвшинг хамгаалахад Циклийн үлдэгдэл шалгалт (CRC) -ийн 32 эсхүл 24 битийн алгоритмыг тус тус ашиглана;
 - 3.2. энгийн нисэхийн өгөгдлийн бүрэн бүтэн байдлын түвшинг хамгаалахад Циклийн үлдэгдэл шалгалт (CRC)-ийн 16 битийн алгоритмыг ашиглаж болно.

(в) Энэ хавсралтын хүснэгтүүдэд заасан нарийвчлалын хэмжээний шаардлагад нийцсэн нисэхийн өгөгдөл нь 95 хувийн итгэлцлийн түвшинг хангана.

(г) Хэмжилт хийх/бэлтгэхээс эхлээд дараагийн хэрэглэгч хүртэлх өгөгдлийн боловсруулалтын бүхий л явцад нисэхийн өгөгдлийн бүрэн бүтэн байдлыг тухайн үйл явцад оролцогч этгээд хариуцна. Нисэхийн өгөгдлийн бүрэн бүтэн байдалд тавигдах шаардлага нь өгөгдлийн алдаанаас болон түүний тодорхой элементийг ашигласнаас үүсэх эрсдэл дээр үндэслэгдсэн болно.

Нисэхийн өгөгдлийн чанарын шаардлага**Хүснэгт 1. Өргөрөг ба уртраг**

№	Өргөрөг ба уртраг	Хэвлэлийн зөвшөөрөгдөх хэмжээ	Нарийвчлалын хэмжээ, өгөгдлийн төрөл	Бүрэн бүтэн байдлын ангилал
1.	Нислэгийн мэдээллийн районы хилийн цэг Flight information region boundary points	1 мин	2 км зарлагдсан	1×10^{-3} энгийн
2.	Хориотой, хязгаарлалттай, аюултай бүсийн хилийн цэг (НХУ-тай бүс/хяналттай бүсийн хилээс гадагш) P, R, D area boundary points (outside CTA/CTZ boundaries)	1 мин	2 км зарлагдсан	1×10^{-3} энгийн
3.	Хориотой, хязгаарлалттай, аюултай бүсийн хилийн цэг (НХУ-тай бүс/хяналттай бүсийн хил доторх) P, R, D area boundary points (inside CTA/CTZ boundaries)	1 сек	100 м тооцоологдсон	1×10^{-5} чухал
4.	НХУ-тай бүс/хяналттай бүсийн хилийн цэг CTA/CTZ boundary points	1 сек	100 м тооцоологдсон	1×10^{-5} чухал
5.	Агаарын замын навигацийн тоног төхөөрөмж болон илтгэх цэг, хүлээх бүсийн цэг, хэрэглэлээр нисэх ирэх, хэрэглэлээр нисэн гарах цэг En-route NAVAIDS and fixes, holding, STAR/SID points	1 сек	100 м хэмжигдсэн/тооцоологдсон	1×10^{-5} чухал
6.	Бүс 1 дэх саад (Улсын газар нутаг бүхлээрээ) Obstacles in Area 1 (the entire State territory)	1 сек	50 м хэмжигдсэн	1×10^{-3} энгийн
7.	Аэродром/вертодромын хяналтын цэг Aerodrome/heliport reference point	1 сек	30 м хэмжигдсэн/тооцоологдсон	1×10^{-3} энгийн
8.	Аэродром/вертодромын навигацийн тоног төхөөрөмж NAVAIDS located at the aerodrome/heliport	1/10 сек	3 м хэмжигдсэн	1×10^{-5} чухал
9.	Бүс 3 дахь саад Obstacles in Area 3	1/10 сек	0.5 м хэмжигдсэн	1×10^{-5} чухал
10.	Бүс 2 дахь саад Obstacles in Area 2	1/10 сек	5 м хэмжигдсэн	1×10^{-5} чухал
11.	Ойртолтын сүүлийн шатны хянах цэг/цэг	1/10 сек	3 м хэмжигдсэн/	1×10^{-5} чухал

	болон хэрэглэлээр ойртолт үйлдэх журмын бусад чухал цэг Final approach fixes/points and other essential fixes/points comprising the instrument approach procedure		ТООЦООЛОГДСОН	
12.	ХБЗ-ын босго Runway threshold	1/100 сек	1 м хэмжигдсэн	1×10^{-8} эсдэлтэй
13.	ХБЗ-ын төгсгөл Runway end (flight path alignment point)	1/100 сек	1 м хэмжигдсэн	1×10^{-8} эсдэлтэй
14.	ХБЗ-ын хүлээх байрлалын цэг Runway holding position	1/100 сек	0.5 м хэмжигдсэн	1×10^{-8} эсдэлтэй
15.	ЯЗ-ын тэнхлэг/зогсоол руу хөтлөх шугамын цэг Taxiway centre line/parking guidance line points	1/100 сек	0.5 м хэмжигдсэн	1×10^{-8} эсдэлтэй
16.	ЯЗ-ын огтлолцолын тэмдэглэх шугам Taxiway intersection marking line	1/100 сек	0.5 м хэмжигдсэн	1×10^{-8} эсдэлтэй
17.	Гарах гарцын шугам Exit guidance line	1/100 сек	0.5 м хэмжигдсэн	1×10^{-8} эсдэлтэй
18.	Агаарын хөлгийн зогсоолын байрлалын цэг /Навигацийн энерцийн систем шалгах цэг Aircraft stand points/INS checkpoints	1/100 сек	0.5 м хэмжигдсэн	1×10^{-3} энгийн
19.	Вертодромын газардах хөөрөх бүс(TLOF)-ийн геометр төв эсхүл ойртолтын сүүлчийн шат болон хөөрөх бүс(FATO)-ийн босго Geometric centre of TLOF or FATO thresholds, heliports	1/100 сек	1 м хэмжигдсэн	1×10^{-8} эсдэлтэй
20.	Перроны хил (олон өнцөгт) Apron boundaries (polygon)	1/10 сек	1 м хэмжигдсэн	1×10^{-3} энгийн
21.	Мөс арилгах/мөсгүй байлгах төхөөрөмж (олон өнцөгт) De-icing/anti-icing facility (polygon)	1/10 сек	1 м хэмжигдсэн	1×10^{-3} энгийн
22.	ХБЗ-ны тэнхлэгийн шугамын цэг Runway centre line points	-	1 м хэмжигдсэн	1×10^{-8} эсдэлтэй
23.	Нисдэг тэрэгний зогсоолын цэг/ Навигацийн энерцийн систем шалгах цэг Helicopter standpoints/INS checkpoints	-	0.5 м хэмжигдсэн	1×10^{-3} энгийн

Хүснэгт 2. Өндөр (үнэмлэхүй/харьцангуй)

№	Өндөр(үнэмлэхүй /харьцангуй)	Хэвлэлийн зөвшөөрөгдөх хэмжээ	Нарийвчлалын хэмжээ, Өгөгдлийн төрөл	Бүрэн бүтэн байдлын ангилал
1.	Аэродром/вертодромын өндөр <i>Aerodrome/heliport elevation</i>	1 м	0.5 м хэмжигдсэн	1×10^{-5} чухал
2.	Аэродром/вертодромын өндрийн байрлал дахь WGS-84 геоидын долгион <i>WGS-84 geoid undulation at aerodrome/heliport elevation position</i>	1 м	0.5 м хэмжигдсэн	1×10^{-5} чухал
3.	Нарийвчлалтай бус ойртолтын ХБЗ эсхүл FATO-ын босго <i>Runway or FATO threshold, non-precision approaches</i>	1 м	0.5 м хэмжигдсэн	1×10^{-5} чухал
4.	Нарийвчлалтай бус ойртолтын ХБЗ эсхүл FATO-ын босго, TLOF-ын геометр төв дээрх WGS-84 геоидын долгион <i>WGS-84 geoid undulation at runway or FATO threshold, TLOF geometric centre, non-precision approaches</i>	==	0.5 м хэмжигдсэн	1×10^{-5} чухал
5.	Нарийвчлалтай ойртолтын ХБЗ эсхүл FATO-ын босго <i>Runway or FATO threshold, precision approaches</i>	0.1 м	0.25 м хэмжигдсэн	1×10^{-8} эрсдэлтэй
6.	Нарийвчлалтай ойртолтын ХБЗ эсхүл FATO-ын босго, TLOF-ын геометр төв дээрх WGS-84	0.1 м	0.25 м хэмжигдсэн	1×10^{-8} эрсдэлтэй

	геоидын долгион WGS-84 geoid undulation at runway or FATO threshold, TLOF geometric centre, precision approaches			
7.	Нарийвчлалтай ойртолтын ХБЗ-ны босгыг хөндлөн огтлох харьцангуй өндөр Threshold crossing height, precision approaches	0.1 м	0.5 м тооцоологдсон	1×10^{-8} эрсдэлтэй
8.	Бүс 2 дахь саад Obstacles in Area 2	1 м	3 м тооцоологдсон	1×10^{-5} чухал
9.	Бүс 3 дахь саад Obstacles in Area 3	0.1 м	0.5 м хэмжигдсэн	1×10^{-5} чухал
10.	Бүс 1 дэх саад (Улсын газар нутаг бүхлээрээ) Obstacles in Area 1 (the entire State territory)	1 м	30 м хэмжигдсэн	1×10^{-3} энгийн
11.	Алслалт хэмжих төхөөрөмж/нарийвчлалтай (DME/P) Distance measuring equipment/precision (DME/P)	3 м	3 м хэмжигдсэн	1×10^{-5} чухал
12.	Алслалт хэмжих төхөөрөмж (DME) Distance measuring equipment (DME)	30 м	30 м хэмжигдсэн	1×10^{-5} чухал
13.	Хамгийн бага үнэмлэхүй өндөр Minimum altitudes	50 м	50 м тооцоологдсон	1×10^{-3} энгийн
14.	Саадаас чөлөөлөгдөх үнэмлэхүй/харьцангуй өндөр Obstacle clearance altitude/height (OCA/H)	-	PANS-OPS Дос-8168-д зааснаар	1×10^{-5} чухал
15.	Хэрэглэлээр ойртолт үйлдэх журмын үнэмлэхүй өндөр Instrument approach procedures altitude	-	PANS-OPS Дос-8168-д зааснаар	1×10^{-5} чухал
16.	ХБЗ-ны тэнхлэг шугамын цэг Runway centre line points	-	0.25 м хэмжигдсэн	1×10^{-8} эрсдэлтэй
17.	ЯЗ-ын тэнхлэг/зогсоол руу хөтлөх шугамын цэг Taxiway centre line/parking guidance line points	-	1 м хэмжигдсэн	1×10^{-5} чухал

Хүснэгт 3. Хазайлт ба соронзон хазайлт

№	Хазайлт ба соронзон хазайлт	Хэвлэлийн зөвшөөрөгдөх хэмжээ	Нарийвчлалын хэмжээ, өгөгдлийн төрөл	Бүрэн бүтэн байдлын ангилал
1.	Тоног төхөөрөмжийн техникийн тохируулга хийхэд ашиглагддаг VHF навигацыйн станцын хазайлт VHF NAVAID station declination used for technical line-up	1 градус	1 градус хэмжигдсэн	1×10^{-5} чухал
2.	Чиглүүлэх станц(NDB)-ын соронзон хазайлт NDB NAVAID magnetic variation	1 градус	1 градус хэмжигдсэн	1×10^{-3} энгийн
3.	Аэродром/вертодромын соронзон хазайлт Aerodrome/heliport magnetic variation	1 градус	1 градус хэмжигдсэн	1×10^{-5} чухал
4.	Хэрэглэлээр буулт үйлдэх систем(ILS)-ийн курсын радиомаяжийн антенны соронзон хазайлт ILS localizer antenna magnetic variation	1 градус	1 градус хэмжигдсэн	1×10^{-5} чухал
5.	Буулт үйлдэх хэт богино долгионы систем(MLS)-ийн азимутын антенны соронзон хазайлт MLS azimuth antenna magnetic variation	1 градус	1 градус хэмжигдсэн	1×10^{-5} чухал

Хүснэгт 4. Чиглэл

№	Чиглэл	Хэвлэлийн зөвшөөрөгдөх хэмжээ	Нарийвчлалын хэмжээ, өгөгдлийн төрөл	Бүрэн бүтэн байдлын ангилал
1.	Агаарын замын хэсэг Airway segments	1 градус	1/10 градус тооцоологдсон	1×10^{-3} энгийн
2.	Аэродромын бүс болон агаарын зам дахь хянах цэг En-route and terminal fix formations	1/10 градус	1/10 градус тооцоологдсон	1×10^{-3} энгийн
3.	Аэродромын бүсийн нисэн ирэх /нисэн гарах замын хэсэг Terminal arrival/departure route segments	1 градус	1/10 градус тооцоологдсон	1×10^{-3} энгийн
4.	Хэрэглэлээр ойртолт үйлдэх журмын хянах цэг Instrument approach procedure fix formations	1/100 градус	1/100 градус тооцоологдсон	1×10^{-5} чухал
5.	Хэрэглэлээр буулт үйлдэх систем(ILS)-ийн курсын радиомаякийн чиг шулуун (жинхэнэ) ILS localizer alignment (True)	1/100 градус	1/100 градус хэмжигдсэн	1×10^{-5} чухал
6.	Буулт үйлдэх хэт богино долгионы систем(MLS)-ийн тэг азимутын чиг шулуун (жинхэнэ) MLS zero azimuth alignment (True)	1/100 градус	1/100 градус хэмжигдсэн	1×10^{-5} чухал

7.	ХБЗ болон FATO-н чиглэл (жинхэнэ) Runway and FATO bearing (True)	1/100 градус	1/100 градус хэмжигдсэн	1×10^{-3} энгийн
----	---	--------------	----------------------------	------------------------------

Хүснэгт 5. Урт/зай/хэмжээ

№	Урт/зай/хэмжээ	Хэвлэлийн зөвшөөрөгдөх хэмжээ	Нарийвчлалын хэмжээ, өгөгдлийн төрөл	Бүрэн бүтэн байдлын ангилал
1.	Агаарын замын хэсгийн урт Airway segment length	1/10 км	1/10 км тооцоологдсон	1×10^{-3} энгийн
2.	Агаарын замын цэгүүдийн хоорондох зай En-route fix formation distance	1/10 км	1/10 км тооцоологдсон	1×10^{-3} энгийн
3.	Аэродромын бүсийн нисэн ирэх /нисэн гарах замын хэсгийн урт Terminal arrival/departure route segment length	1/100 км	1/100 км тооцоологдсон	1×10^{-5} чухал
4.	Аэродром болон хэрэглэлээр ойртолт үйлдэх журмын хянах цэгүүдийн хоорондох зай Terminal and instrument approach procedure fix formation distance	1/100 км	1/100 км тооцоологдсон	1×10^{-5} чухал
5.	ХБЗ болон FATO-н урт, TLOF-ын хэмжээ Runway and FATO length, TLOF dimensions	1 м	1м хэмжигдсэн	1×10^{-8} эрсдэлтэй
6.	ХБЗ-ын өргөн Runway width	1 м	1м хэмжигдсэн	1×10^{-5} чухал
7.	Шилжсэн босгоны зай Displaced threshold distance	1 м	1м хэмжигдсэн	1×10^{-3} энгийн
8.	Саадаас чөлөөлөгдсөн зурвасны урт ба өргөн	1 м	1м хэмжигдсэн	1×10^{-5} чухал

	<i>Clearway length and width</i>			
9.	Тормослох зурвасны урт ба өргөн <i>Stopway length and width</i>	1 м	1м хэмжигдсэн	1×10^{-8} эрсдэлтэй
10.	Буултын боломжит зай <i>Landing distance available</i>	1 м	1м хэмжигдсэн	1×10^{-8} эрсдэлтэй
11.	Хөөрөлтийн боломжит урт <i>Take-off run available</i>	1 м	1м хэмжигдсэн	1×10^{-8} эрсдэлтэй
12.	Хөөрөлтийн боломжит зай <i>Take-off distance available</i>	1 м	1м хэмжигдсэн	1×10^{-8} эрсдэлтэй
13.	Хөөрөлтийг зогсоох боломжит зай <i>Accelerate-stop distance available</i>	1 м	1м хэмжигдсэн	1×10^{-8} эрсдэлтэй
14.	ХБЗ-ны хажуугийн аюулгүйн зурвасны өргөн <i>Runway shoulder width</i>	1 м	1м хэмжигдсэн	1×10^{-5} чухал
15.	Явгалах замын өргөн <i>Taxiway width</i>	1 м	1м хэмжигдсэн	1×10^{-5} чухал
16.	Явгалах замын хажуугийн аюулгүйн зурвасны өргөн <i>Taxiway shoulder width</i>	1 м	1м хэмжигдсэн	1×10^{-5} чухал
17.	Хэрэглэлээр буулт үйлдэх систем(ILS)-ийн курсын радиомаякийн антенн болон ХБЗ-ын төгсгөлийн хоорондын зай <i>ILS localizer antenna-runway end, distance</i>	1 м	3м тооцоологдсон	1×10^{-3} энгийн
18.	Хэрэглэлээр буулт үйлдэх систем(ILS)-ийн глиссадын радиомаякийн антенн болон ХБЗ-ын босго хоорондын тэнхлэгийн дагуух зай <i>ILS glide slope antenna-threshold, distance along centre line</i>	1 м	3м тооцоологдсон	1×10^{-3} энгийн
19.	Хэрэглэлээр буулт үйлдэх систем(ILS)-ийн маркер болон ХБЗ-ын босго хоорондын зай <i>ILS marker-threshold distance</i>	1 м	3м тооцоологдсон	1×10^{-5} чухал
20.	Хэрэглэлээр буулт үйлдэх систем(ILS)-ийн алслалт хэмжих төхөөрөмж(DME)-ийн антенн болон ХБЗ-ын босго хоорондын тэнхлэгийн дагуух зай <i>ILS DME antenna-threshold, distance along centre line</i>	1 м	3м тооцоологдсон	1×10^{-5} чухал
21.	Буулт үйлдэх хэт богино долгионы систем(MLS)-ийн азимутын антенн болон ХБЗ-ын төгсгөлийн хоорондох зай <i>MLS azimuth antenna-runway end,</i>	1 м	3м тооцоологдсон	1×10^{-3} энгийн

	<i>distance</i>			
22.	Буулт үйлдэх хэт богино долгионы систем(MLS)-ийн өндрийн антенн болон ХБЗ-ын босго хоорондын тэнхлэгийн дагуух зай <i>MLS elevation antenna-threshold, distance along centre line</i>	1 м	3м тооцоологдсон	1×10^{-3} ЭНГИЙН
23.	Буулт үйлдэх хэт богино долгионы систем(MLS)-ийн алслалт хэмжих төхөөрөмж(DME)-ийн антенн болон ХБЗ-ын босго хоорондын тэнхлэгийн дагуух зай <i>MLS DME/P antenna-threshold, distance along centre line</i>	1 м	3м тооцоологдсон	1×10^{-5} чухал
